

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2023 оны 11 дүгээр сарын 27 өдөр

1. Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд:

- Модны үр, тарьц, суулгацын хяналт, борлуулалт, тээвэрлэлттэй холбоотой одоо байгаа үйл явц, мэдээллийн урсгалыг үнэлэх.
- Төслийн зорилгод нийцсэн мэдээллийн технологийн нэгдсэн системийг зохион бүтээх.
- Хэрэглэгчдэд ээлтэй интерфэйс, шаардлагатай функцуудыг багтаасан мэдээллийн технологийн системийг хөгжүүлэх.
- Одоо байгаа дэд бүтэц болон системтэй нийцтэй байдлыг баталгаажуулж системийг хэрэгжүүлнэ.
- Системийг боловсруулахдаа terbutmod.mn порталтай нягт уялдуулж, нэг бүрэлдэхүүн хэсэг нь болгож боловсруулах

Модны үр, тарьц, суулгацын тарьц, суулгацын гарал үүслийг нэгдсэн байдлаар хянах, борлуулах цахим систем (IT)-ийг бий болгох юм. Энэ систем нь модны үр, тарьц, суулгацын тарьц, суулгацын гарал үүсэл, чанар, түгээлт, борлуулалтын үйл явцыг оновчтой болгох, сайжруулах нь энэхүү зөвлөх үйлчилгээний зорилготой юм.

2. Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14–16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ.

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Байгууллагын ерөнхий танилцуулга;
- Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт;
- Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай цахим тодорхойлолт;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт;
- Шүүхийн төрөлжсөн /тусгай/ архивын лавлагаа, Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолт;
- Гэрээт ажлын гүйцэтгэгч нь мэдээллийн технологи, IT чиглэлээр мэргэшсэн хувь хүн эсвэл судалгааны байгууллага, хуулийн этгээд байх ба мэдүүлэг ирүүлэгч нь хуулийн этгээдийн ерөнхий нөхцөлийг магадлахад шаардагдах баримт бичиг, тодорхойлолтууд болон санал болгож буй хувь хүн эсвэл багийн гишүүдийн боловсрол, ажлын туршлага, ижил төстэй ажлын жагсаалт ирүүлнэ.
- Ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл.

3. Сонирхсон хуулийн этгээд нэмэлт мэдээллийг **2023** оны **12** дугаар сарын **4**-ний өдрийг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ **2023** оны **12 дугаар** сарын 4-ны өдрийн **11.00** цагаас өмнө ирүүлнэ үү.

4. Зөвлөхийн баримт бичгийг Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Холбоо барих этгээд: Төслийн худалдан авалтын ажилтан
tender@gcf-rural.mn, Утас: 75057507